



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/1851

Чойр

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, 29.2, Засгийн газрын 2016 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг шинээр болон өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн харьяалах сумд, агентлаг, хамаарал бүхий байгууллагыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Нэршилд нь өөрчлөлт орсон байгууллагууд бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн тогтоосон шийдвэр гарах хүртэлх хугацаанд тогтоосон бүтэц, орон тооны хүрээнд хуучин дүрмийг дагаж, мөрдөж ажиллахыг тухайн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Баянтал, Сүмбэр, Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар, агентлаг, хэлтэс, газруудыг чиг үүргийнхээ дагуу харьяалалдаа авч ажиллах, бодлогын удирдамж, удирдлага арга зүйгээр хангаж, үйл ажиллагааг чиглүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Содном/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны “Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын жагсаалтыг батлах тухай” А/185 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2016 оны
08 сарын 22-ны өдрийн 1457 дугаар
захирамжийн 1 дугаар хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ЖАГСААЛТ**

1. Байгаль орчин, аялал жуулчлалын газар;
2. Биеийн тамир, спортын газар;
3. Боловсрол, соёл, урлагийн газар /Урьд нь Боловсрол, соёлын газар байсан/;
4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;
5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Урьд нь Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс байсан/;
6. Мэргэжлийн хяналтын газар;
7. Онцгой байдлын газар;
8. Орон нутгийн өмчийн газар /Худалдан авах ажиллагааны албатай/;
9. Санхүүгийн хяналт, аудитын алба;
10. Статистикийн хэлтэс;
11. Татварын хэлтэс;
12. Улсын бүртгэлийн хэлтэс;
13. Ус, цаг уур, орчны шинжилгээний алба;
14. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Урьд нь Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс байсан/;
15. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
16. Цагдаагийн хэлтэс;
17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба;
18. Шүүхийн шинжилгээний алба;
19. Эрүүл мэндийн газар /Зоонозын өвчин судлалын албатай/;
20. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс /Урьд нь Нийгмийн даатгалын хэлтэс байсан/;

Аймгийн Засаг даргын 2016 оны
 29 сарын 16-ны өдрийн 1427 дугаар
 захирамжийн 2 дугаар хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЭЛТСҮҮДЭД
 ХАРЬЯАЛАГДАХ СУМ, АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГА**

№	Байгууллагыг харьяалах хэлтэс	Агентлагууд		Хамаарал бүхий байгууллагууд		
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	1	Онцгой байдлын газар			
		2	Мэргэжлийн хяналтын газар			
		3	Баянтал сум			
		4	Сүмбэр сум			
		5	Шивээговь сум			
2	Хууль, эрх зүйн хэлтэс	6	Цагдаагийн хэлтэс			
		7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба			
		8	Шүүхийн шинжилгээний алба			
		9	Улсын бүртгэлийн хэлтэс			
3	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	10	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба			
		11	Орон нутгийн өмчийн газар (Худалдан авах ажиллагааны албатай)			
		12	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	Ойн анги	
		13	Хүнс, хөдөө аж ахуйн газар	2	Цөм сүргийн үржлийн төв	
		14	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	3	“Ус-Ду” ААТОНӨҮГ	
				4	“Талын-Илч” ААТОНӨҮГ	
				5	“Илчлэг-Шивээ” ААТОНӨҮГ	
				6	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний Чойр дахь салбар	
				7	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгааны түгээх сүлжээ ТӨХК-ний Говьсүмбэр аймаг дахь салбар	
				8	Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХК-ний Дорноговь аймгийн газрын Говьсүмбэр салбар	
				9	Монголын цахилгаан холбоо ТӨХК-ний Говьсүмбэр аймгийн	

					Холбооны газар	
				10	Автотээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбар	
4	Нийгмийн бодлогын хэлтэс	15	Биеийн тамир, спортын газар			
		16	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар			
		17	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар			
		18	Эрүүл мэндийн газар	11	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	
				12	Энхтус дэм Эрүүл мэндийн төв	
				13	Баянтал сумын Эрүүл мэндийн төв	
				14	Шивээговь сумын Эрүүл мэндийн төв	
		19	Боловсрол, урлагийн газар соёл,	15	Боржигин өв музей	
				16	Дуу бүжгийн боржигин чуулга	
				17	Нийтийн номын сан	
				18	Насан туршийн боловсролын төв	
				19	Шивээговь сумын Соёлын төв	
				20	Баянтал сумын Соёлын төв	
				21	1 дүгээр сургууль	
				22	2 дугаар сургууль	
				23	3 дугаар сургууль	
				24	4 дүгээр сургууль	
				25	5 дугаар сургууль	
				26	1 дүгээр цэцэрлэг	
		27	2 дугаар цэцэрлэг			
28	3 дугаар цэцэрлэг					
29	4 дүгээр цэцэрлэг					
30	5 дугаар цэцэрлэг					
5	Санхүү, төрийн сангийн хэлтэс	20	Санхүүгийн хяналт, аудитын алба			
		21	Статистикийн хэлтэс			
		22	Татварын хэлтэс			
		23	Эрүүл, мэнд, нийгмийн даатгалын хэлтэс			